



Аудитын код: САГ-2017/18/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 260152 Цахим хаяг: sambuunymya@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Золзаяа

Утас: 260152 Цахим хаяг: zolzayan@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.5	Дотоод хяналт	6
2.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.7	Шилэн дансны мэдээлэл	7
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	8
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Цалин хөлстэй холбогдох тооцооллын талаар	9
2.9.2	Тооллогын бүртгэлийн талаар.....	9
2.9.3	Батлагдсан орон тоо хэтрүүлэн ажилласан талаар	9
2.9.4	Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар	9
2.9.5	Анхан шатны баримтын бүрдлийн талаар.....	10
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	10
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	10
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	11
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	12
3.1	Цалин хөлстэй холбогдох тооцооллын талаар	13
3.2	Тооллогын бүртгэлийн талаар	14
3.3	Батлагдсан орон тоо хэтрүүлэн ажилласан талаар	15
3.4	Элэгдлээрээ өртгөө нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийн талаар	16
3.5	Анхан шатны баримтын бүрдлийн талаар	17
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	18
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	18
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	19
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	21
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	22

1 Аудитын гэрчилгээ



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.04.25 № 773
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Үндэсний статистикийн хорооны дарга Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.


Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорилоор олж авсан нотлох зүйлс, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Зөрчилгүй санал дүгнэлт

Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Үндэсний статистикийн хорооны дарга А.Ариунзаяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 10-наас 2017 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Н.Золзаяа хариуцаж хэрэгжүүлэв.

Үндэсний статистикийн хорооны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан болно.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Үндэсний статистикийн хорооны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 8 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2015 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн яамнаас 2016 онд авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэж байна. Гэвч дараах асуудлыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дэлгэрэнгүй тусгах нь зүйтэй. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал;

Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Пластик” програм хангамж ашиглажээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Дотоод аудитын хэлтсийг Үндэсний статистикийн хорооны даргын 2016 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/02 тушаалаар 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ.

Тус хэлтэс Үндэсний статистикийн хорооны төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчдын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, санхүүгийн тайлан, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлж, эрсдэлийн удирдлагаар хангах ажлыг эрхлэн гүйцэтгэж байна.

Дотоод аудитын хэлтэс тухайн онд Үндэсний статистикийн хорооны болон Говьсүмбэр аймгийн статистикийн хэлтсийн 2016 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийжээ.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Үндэсний статистикийн хорооны даргын төсөвт 6 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд 2,891.8 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2,667.0 сая төгрөг буюу 92.2 хувьтай байгаа нь Сангийн яам улс орны эдийн засгийн хүндрэлтэй байдлын улмаас төлөвлөсөн зарим зардлын эрхийг хязгаарлах бодлоготой холбоотой 224.8 сая төгрөгөөр санхүүжилтийг дутуу олгосон байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсвийн гүйцэтгэлд анхаарал татахуйц их хэмжээний хэлбэлзэл алга байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Үндэсний статистикийн хорооны дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Үндэсний статистикийн хороо өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Дараа жилийн төсвийн төсөл (бүтэн жилээр)
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүр, сар бүр)

3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (тухай бүр)
4. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (бүтэн жилээр, хагас жилээр)
5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (бүтэн жилээр, хагас жилээр)
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (тухай бүр)
7. Санхүүгийн тайлан (бүтэн жилээр, хагас жилээр)
8. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (бүтэн жилээр)
9. Байгууллагын батлагдсан төсөв (бүтэн жилээр)

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хүрээнд мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллажээ.

Шилэн дансны сайтад мэдээлэл байршуулах төлөвлөгөөний дагуу төсөвт байгууллагын байршуулах 18 төрлийн мэдээллийг давхардсан тоогоор 56 удаа, төсвийн ерөнхийлөн захирагчийн байршуулах 16 мэдээллийг давхардсан тоогоор 45 удаа байршуулж, харьяа байгууллагын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөгөө өгч ажилласан байна.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Үндэсний статистикийн хороотой холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайланд:

Төсвийн шууд захирагч-32 /Үндэсний статистикийн хорооны аппарат, 21 аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс- болон 9 дүүргийн статистикийн хэлтэс, Хүн ам орон сууцны тооллогын товчоо/

Төсөл хөтөлбөрийн нэгж-1 /Монголын үндэсний статистикийг сайжруулах төсөл/, нийт 33 байгууллагын тайлан нэгтгэгдсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитад 27 байгууллага хамрагдсан ба 26 зөрчилгүй, 1 хязгаарлалтай дүгнэлт авсан бөгөөд 6 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

2.9.1 Цалин хөлстэй холбогдох тооцооллын талаар

Нийслэл болон 8 дүүргийн статистикийн хэлтсүүдэд 32.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба нийтлэгээр цалин хөлс, ээлжийн амралтын олговор болон тэдгээртэй холбоотой татварын хөнгөлөлт, нийгмийн даатгалын шимтгэлийг буруу тооцож илүү, дутуу олгосон нь Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай “Үнэн зөв байдал” мэдэгдэлтэй зөрчилдөж байна.

“Үнэн зөв байдал”- Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх/

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх

2.9.2 Тооллогын бүртгэлийн талаар

Дорнод, Ховд аймгийн статистикийн хэлтсүүд хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн

12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”,

12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1.-т “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө,” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх

2.9.3 Батлагдсан орон тоо хэтрүүлэн ажилласан талаар

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэх тухай” 12 дугаар тогтоолоор Үндэсний статистикийн хорооны бүтэц, орон тоог 320 хүнтэй байхаар баталсан байна.

Гэвч 2016 онд батлагдсан орон тооноос хэтрүүлэн хэвлэх цехэд 6 гэрээт ажилтан ажиллуулж 8.1 сая төгрөгийг цалингийн төсвөөс олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2 -т “Жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж хэрэгжүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй хийх, батлагдсан орон тоог хэтрүүлэхгүйгээр ажиллах зөвлөмж өгөх

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна.

2.9.4 Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 171 нэр төрлийн 980.9 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгө элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн боловч дахин үнэлгээ хийгдээгүй ашиглагдаж байна.

Энэ нь УСНББОУС-17-19-д “Хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Холбогдох эрх бүхий байгууллагаар асуудлыг шийдвэрлүүлэх,

2. Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөх талаар зөвлөмж өгөх,

2.9.5 Анхан шатны баримтын бүрдлийн талаар

Үндэсний статистикийн хорооны аппарат болон Төв, Ховд, Говь-Алтай аймгууд, Чингэлтэй, Хан-Уул, Сүхбаатар, Налайх дүүргийн статистикийн хэлтсүүд анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарим ажил гүйлгээг бүртгэсэн байна. Тухайлбал: Гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй 4.0 сая төгрөгийг олгосон, Үндэсний статистикийн хорооны аппарат бэлэн мөнгөний бүх зарлагад кассын зарлагын ордер хөтлөөгүй, дотоод томилолтын ажлын тайлан гаргаагүй, жолоочийн замын хуудас нь илүү дутуу бичигдсэн, Ховд аймгийн статистикийн хэлтэс няравын тайлан гаргаж тооцоо бодоогүй, материалын үлдэгдэл баталгаажуулаагүй, кассын тайлан гаргаж тооцоо хийгээгүй байна.

Эдгээр зөрчлүүд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, 19 дүгээр зүйлийн 19.1.5-д “Эд хөрөнгө, өр төлбөрийн хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах

2.Анхан шатны баримтын бүрдэл болоогүй ажил гүйлгээг хийхгүй байх талаар зөвлөмж өгөх

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж байгаа “Э-тайлан” програм хангамж хэвийн ажиллаагүй, санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлагнасан хөрөнгийн санхүүжилт, урсгал зардал, гадаад зээлийн санхүүжилт, өр авлагын нэмэлт санхүүжилт болон бусад холбогдох тооцоог Сангийн яамтай тооцоо бүрэн нийлж баталгаажуулаагүй, төв төрийн сангийн төсвийн хэлбэлзлийн тайлан эцэслэгдээгүй, нэгтгэлийн “Э-тайлан” програмаас хэвлэгдэж буй санхүүгийн байдлын тайланд Засгийн газрын хувь оролцооны дүн дутуу татагдсан зэрэг нь Үндэсний статистикийн хорооны даргын санхүүгийн нэгтгэсэн тайланг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлэхэд зарим тоон мэдээлэл өөрчлөгдөх эрсдэл үүсгэх магадлалтай байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Тусгайлан анхаарах асуудал байхгүй байна.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 1,214.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 122.4 сая төгрөгийн материаллаг алдааг аудитын явцад залруулж, 1.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 60.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага тавьж, 1029,6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 4 сарын 12-нд 01/422 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Зөвлөмжийн биелэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн материаллаг байдлын суурийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,892.8 сая төгрөгөөр тооцсон бөгөөд түүний 2 хувь 97.8 сая төгрөгөөр түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бид Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон холбогдох бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

**3.1 Цалин хөлстэй холбогдох тооцооллын
ТАЛААР**

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Нийслэл болон 8 дүүргийн статистикийн хэлтсүүдэд 32.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба цалин хөлс, ээлжийн амралтын олговор болон тэдгээртэй холбоотой татварын хөнгөлөлт, нийгмийн даатгалын шимтгэлийг буруу тооцож илүү, дутуу олгосон нийтлэг алдаа байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэл

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ

3.2 Тооллогын бүртгэлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Дорнод, Ховд аймгийн статистикийн хэлтсүүд хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн

12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”,

12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”,

12.2.1.-т “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэл

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ

**3.3 БАТЛАГДСАН ОРОН ТОО ХЭТРҮҮЛЭН
АЖИЛЛАСАН ТАЛААР**

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

320 хүний орон тоо батлагдсан боловч байгууллагын дэргэд ажиллах хэвлэх цехийн 6 ажилтанг гэрээт ажилтны цалингийн төсвөөс цалинжуулан, 6 орон тоогоор нэмэгдүүлэн ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2 -т “Жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж хэрэгжүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй хийх, батлагдсан орон тоог хэтрүүлэхгүйгээр ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ

**3.4 Элэгдлээрээ өртгөө нөхсөн үлдэх
өртөггүй хөрөнгийн талаар**

Тэргүүлэх ач холбогдол №4

ҮАГ-ын ажиглалт

Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 171 нэр төрлийн 980.9 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгө ашиглагдаж байна.

Энэ нь УСНББОУС-17-19-д “Хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Холбогдох эрх бүхий байгууллагаар асуудлыг шийдвэрлүүлэх

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

**3.5 АНХАН ШАТНЫ БАРИМТЫН БҮРДЛИЙН
ТАЛААР**

Тэргүүлэх ач холбогдол №4

ҮАГ-ын ажиглалт

Үндэсний статистикийн хорооны аппарат болон Төв, Ховд, Говь-Алтай аймгууд, Чингэлтэй, Хан-Уул, Сүхбаатар, Налайх дүүргийн статистикийн хэлтсүүд анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарим ажил гүйлгээг бүртгэсэн байна. Тухайлбал: Гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй 4.0 сая төгрөгийг олгосон, Үндэсний статистикийн хорооны аппарат бэлэн мөнгөний бүх зарлагад кассын зарлагын ордер хөтлөөгүй, дотоод томилолтын ажлын тайлан гаргаагүй, жолоочийн замын хуудас нь илүү дутуу бичигдсэн зэрэг зөрчлүүд байна.

Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, 19 дүгээр зүйлийн 19.1.5-д “ эд хөрөнгө, өр төлбөрийн хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах анхан шатны баримтын бүрдэл болоогүй ажил гүйлгээг хийхгүй байх,

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	568,525.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	267,527.3
33	АВЛАГА	0.00	123,181.4
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	177,817.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	1,784,604.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	1,784,604.6
39200	Биет хөрөнгө	0.00	1,618,895.8
39300	Биет бус хөрөнгө	0.00	165,708.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	2,353,130.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	25,629.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	25,629.4
41300	Өглөг	0.00	25,629.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	2,327,501.0
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	2,327,501.0
51200	Хуримтлагдсан үр дүн	0.00	2,327,501.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	2,353,130.4

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		6,329,148.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		2,682,547.4
120	Нийтлэг татварын бус орлого		2,290,041.4
122	Тусламжийн орлого		392,506.0
122002	Хандив тусламж /гадаад/		392,506.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,646,601.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		4,001,647.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,001,647.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,868,495.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,477,328.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		163,120.6
2104	Хангамж, бараа материалын зардал		148,513.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,242.8
2107	Томилолт, зочны зардал		87,670.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,356,671.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		632,948.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		133,151.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		2,327,501.0
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		2,327,501.0

4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН
11	2016 оны 1-р сарын 1- нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
18	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,327,501.0	2,327,501.0
19	2016 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,327,501.0	2,327,501.0

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		4,159,905.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		503,788.7
120	Нийтлэг татварын бус орлого		111,282.7
122	Тусламжийн орлого		392,506.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,656,116.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,889,878.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,889,878.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,638,525.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,379,326.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		153,905.1
2104	Хангамж, бараа материалын зардал		147,774.6
2105	Нормативт зардал		0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		97,256.7
2107	Томилолт, зочны зардал		83,076.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,409,495.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		367,689.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		251,353.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		270,027.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		2,500.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		2,500.0
2200	Дотоод эх үүсвэрээр		2,500.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-2,500.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		267,527.3
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		267,527.3

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	ЗӨРҮҮ	ХУВЬ
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,891,853.9	2,667,053.3	224,800.6	92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,891,853.9	2,667,053.3	224,800.6	92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,766,070.4	2,566,649.5	199,420.9	93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,285,616.0	1,281,850.3	3,765.7	100
210101	Үндсэн цалин	931,790.0	938,383.5	-6,593.5	101
210102	Нэмэгдэл	156,897.0	156,897.0	0.00	100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	98,604.0	96,438.4	2,165.6	98
210105	Гэрээт ажлын хөлс	98,325.0	90,131.4	8,193.6	92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,418.7	141,180.4	238.3	100
210201	Тэтгэврийн даатгал	89,993.0	89,454.0	539.0	99
210202	Тэтгэмжийн даатгал	10,285.1	10,067.0	218.1	98
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,856.4	12,857.6	-1.2	100
210204	Ажилгүйдлийн даатгал	2,571.4	2,935.4	-364.0	114
210205	Эрүүл мэндийн даатгал	25,712.8	25,866.3	-153.5	101
2104	Хангамж, бараа материалын зардал	33,454.9	33,453.9	1.0	100.0
210401	Бичиг хэрэг	5,514.3	7,526.8	-2,012.5	136.5
210402	Тээвэр, шатахуун	12,155.7	10,695.6	1,460.1	88.0
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	15,784.9	15,231.4	553.5	96.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,203.1	2,125.0	7,078.1	23.1
210604	Урсгал засвар	9,203.1	2,125.0	7,078.1	23.1
2107	Томилолт, зочны зардал	7,463.3	6,592.5	870.8	88.3
210702	Дотоод албан томилолт	7,463.3	6,592.5	870.8	88.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	899,770.4	870,623.2	29,147.2	96.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	881,749.9	855,560.2	26,189.7	97.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,083.3	780.0	1,303.3	37.4
210803	Даатгалын үйлчилгээ	2,316.4	1,212.0	1,104.4	52.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	179.2	95.4	83.8	53.2
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	39.1	6.5	32.7	16.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,750.0	8,750.0	0.00	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,652.5	4,219.2	433.3	90.7

Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	389,144.0	230,824.3	158,319.7	59.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	388,344.0	230,024.3	158,319.7	59.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800.0	800.0	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125,783.5	100,403.7	25,379.8	79.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	125,783.5	100,403.7	25,379.8	79.8
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	48,150.0	43,400.0	4,750.0	90.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	77,633.5	57,003.7	20,629.8	73.4
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,891,853.9	2,934,580.5	-42,726.6	101.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,497,509.9	2,431,705.6	65,804.3	97.4
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,497,509.9	2,431,705.6	65,804.3	97.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,000.0	110,369.0	-104,368.9	1,839.4
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000.0	110,369.0	-104,368.9	1,839.4
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	388,344.0	392,506.0	-4,162.0	101.1
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	388,344.0	392,506.0	-4,162.0	101.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	267,527.3	-267,527.3	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	679.00	691.00	-12.00	101.8
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	39.00	39.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	39.00	39.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	320.00	326.00	-6.00	101.9
620001	Удирдах ажилтан	34.00	34.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	239.00	239.00	0.00	100.0
620004	Гэрээт ажилтан	47.00	53.00	-6.00	112.8
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	320.00	326.00	-6.00	101.9
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	268.00	273.00	-5.00	101.9
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	5.00	0.00	5.00	0.00
650010	Гэрээт ажилтан	47.00	53.00	-6.00	113.0